

Сангийн сайдын 2013 оны 05 дугаар
сарын 31-ний өдрийн 125 дугаар
тушаалын 1 дүгээр хавсралт



НИЙСЛЭЛИЙН ТҮРГЭН ТУСЛАМЖИЙН ТӨВ

БАГАЖ, ТЕХНИК ХЭРЭГСЭЛ НИЙЛҮҮЛЭХ ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ

Тендерийн нэр: Багаж, техник хэрэгсэл нийлүүлэх харьцуулалтын тендер
Тендерийн дугаар: НТТТ 2019/04003

Улаанбаатар хот
2019 он

ОРШИЛ

“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хууль, тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Сангийн яамнаас боловсруулсан энэхүү үнийн санал авах жишиг баримт бичгийг Захиалагч байгууллага 50,000,000 төгрөгөөс доош төсөвт өртөгтэй бараа нийлүүлэх гүйцэтгэгчийг харьцуулалтын аргаар сонгох болон шууд гэрээ байгуулах үед мөрдөнө.

Үнийн санал авах жишиг бичиг баримтын заалтуудад зарчмын бус өөрчлөлт оруулж тухайн барааг худалдан авах ажиллагаанд тавигдах шаардлагад нийцүүлбэл зохино. Эдгээр өөрчлөлтийг хийхдээ дараах удирдамжийг дагаж мөрдөнө

1. Үнийн санал авах баримт бичгийг худалдан авах бараа буюу төслийн онцлог байдалд нийцүүлэн энэхүү жишиг баримт бичгийн дагуу бэлтгэнэ.
2. Захиалагч налуу үсгээр хаалтанд бичсэн жишээ, зааврын оронд тохирох үг өгүүлбэр, тоо хэмжээ, хувь, валют зэргийг бөглөнө. Үнийн санал ирүүлэгчийн бөглөх хэсгийг захиалагч бөглөхгүй орхино.
3. Үнийн санал авах жишиг баримт бичгийн зүүлт/тайлбар болон санамж нь захиалагчид заавар өгөх зорилготой тул үнийн санал авах баримт бичгийг бэлтгэхдээ тэдгээрийг хасна.

Энэхүү тендерийн баримт бичигтэй холбоотой асуулт ирүүлэх, тайлбар эсвэл нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл дараах хаягаар холбоо барина уу.

Сангийн яамны Хууль, худалдан авах ажиллагааны бодлогын газар

Утас: 267416, 267648

Web: www.e-procurement.mn



ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2019 оны 04 дугаар сарын 01

Тендер шалгаруулалтын нэр: **Багаж, техник хэрэгсэл нийлүүлэх тендер**
Тендер шалгаруулалтын дугаар: **НТТТ/201904003**

Нийслэлийн түргэн тусламжийн төв /НТТТ/ эрх бүхий оролцогчдоос “Багаж, техник хэрэгсэл нийлүүлэх” тухай битүүмжилсэн цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Тус тендер нь 2 багцтай.

Багц1. Конторын техник хэрэгсэл

Багц2. Эмнэлгийн болон автомашины багаж төхөөрөмж

Тухайн тендерт эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр **50,000 / тавин мянган /төгрөгийн хураамж** төлж оролцоно. Тендер нь түүний нээсэн өдрөөс **45** хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерийг **2019 оны 04 дүгээр сарын 15 -ны өдрийн 10 цаг 30 минутаас** өмнө доорх цахим хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2019 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн 11 цаг 00 минутад** нээнэ. Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх цахим хаягаар авч болно.

ЗАХИАЛАГЧИЙН ХАЯГ:

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 6-р хороо, Бага тойрог,
НТТТ-ийн АВТОБААЗ, 106 тоотод. Хангамж үйлчилгээний алба
Утас: 350864, 350869 Факс: 976-321811

Цахим хаяг: www.tender.gov.mn

Хоёр. **ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА**

- | | |
|--|---|
| 1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа | 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна. |
| 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт | 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ. |
| 3. Тендерийн иж бүрдэл | 3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:
(а) Үнийн санал;
(б) Үнийн боло нийлүүлэлтийн хуваарь;
(в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
(г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
(д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.] |
| 4. Тогтмол үнэ | 4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана. |
| 5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд | 5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.
5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ. |
| 6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа | 6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 45 хоногийн хугацаанд хүчинтэй байна. |
| 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх | 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь ТШӨХ-д заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно. |

**8. Гэрээ
байгуулах эрх
олгох тухай
мэдэгдэл**

- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. **ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ**

Худалдан авах барааны талаарх дор дурдсан өгөгдлүүд нь тендерт оролцогчид өгөх зааварчилгаа/ТООЗ/-ны холбогдох зүйл, заалтын мэдээллийг гүйцээх, нэмэлт оруулах, эсхүл өөрчлөх зорилготой. Хэрэв ТООЗ-ны зүйл, заалттай зөрчилдвөл энэхүү хүснэгт дэх мэдээллийг зөв гэж үзнэ.

ТООЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТООЗ 1.1	Захиалагч нь: <i>Нийслэлийн түргэн тусламжийн төв, Сүхбаатар дүүргийн 1-р хороо, Чинван Чагдаржавын гудамж, 1 эмнэлгийн баруун урд талд</i>
ТООЗ 1.1	Нээлттэй тендер шалгаруулалтын нэр болон ялгагдах дугаар нь: <i>Багаж, техник хэрэгсэл нийлүүлэх тендер НТТТ/201904003</i>
ТООЗ 1.2	Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: <i>Багцтай</i> <i>Багц 1. Конторын техник хэрэгсэл</i> <i>Багц 2. Эмнэлгийн болон автомашины багаж төхөөрөмж</i>
ТООЗ 2.1	Санхүүжилтийн эх үүсвэр нь: <i>Батлагдсан урсгал төсвийн хөрөнгөөр</i>
Б. Тендерийн баримт бичиг	
ТООЗ 8.1	Захиалагчаас тендерийн баримт бичигтэй холбоотой тодруулга авах хаяг: <i>[Улаанбаатар хот. Сүхбаатар дүүрэг. 6-р хороо, бага тойрог. НТТТ-ийн АВТОБААЗ. 203 тоот. Утас:350864, Вэб хуудас: www.tender.gov.mn]</i> <i>Гэрээ: Ариутгал, цэвэрлэгээ, хангамжийн материал нийлүүлэх</i> <i>Тендер шалгаруулалт /Гэрээний дугаар: 2019/04003</i>
ТООЗ 8.1	Тендерийн баримт бичгийн талаар тодруулга авах хүсэлтийг хүлээн авах хугацааны хязгаар тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө ажлын 5 хоногоос багагүй байна. Тодруулгын хариуг албан бичгээр Төрийн худалдан авах ажиллагааны www.tender.gov.mn цахим системд байрлуулна.
В. Тендер бэлтгэх	
ТООЗ 12.1 (ё)	Тендерт оролцогч дараах нэмэлт материалыг өөрийн тендерт хавсралтаар ирүүлнэ. Үүнд: <ul style="list-style-type: none"> - Аж ахуйн нэгжийн гэрчилгээний хуулбар - Нийлүүлэхээр санал болгосон бараандаа 1 жил болон түүнээс дээш хугацааны чанарын баталгаа өгөх /албан тоотоор/ - Бараа нийлүүлэлтийн хуваарь ирүүлэх /нийлүүлэхээр санал болгож байгаа бараа нь захиалагчийн техникийн үзүүлэлт болон шаардлагад нийцсэн, тоо ширхэг бүрэн гүйцэд байх / - Барааны үнийн санал ирүүлэх - Тендерт оролцогч нь тендерийн иж бүрдэл, баримт бичгийг

	бэлтгэн электрон хэлбэрт /Adobe PDF / шилжүүлж, цахим хэлбэрээр ирүүлэх ба ирүүлсэн бүх материал тод байх шаардлагатай.
ТООЗ 15.5	Олон улсын худалдааны Incoterms /Инкотермс -ийн хувилбар: <i>[хэвлэгдсэн оныг нь оруул. Жишээ нь: “Incoterms 2010”]</i> .
ТООЗ 15.9 (б) (1) and (в) (3)	Бараа хүргэгдэх газар: <i>Сүхбаатар дүүргийн 6-р хороо Нийслэлийн түргэн тусламжийн төвийн автобааз аж ахуйн хангамжийн албанд</i>
ТООЗ 15.9 (а) (3);(б)(3) болон (в)(5)	“Бараа хүргэгдэх эцсийн цэг (Захиалагчийн агуулах, эсхүл барааг эцсийн хэрэглэгчид хүргэх байршил)”: <i>Нийслэлийн түргэн тусламжийн төвийн автобааз дахь аж ахуйн хангамжийн агуулах/</i>
ТООЗ 15.10	Тендерт оролцогчийн санал болгосон үнийг гэрээний хэрэгжилтийн явцад <i>Тохируулахгүй тогтмол байна .</i> <i>Үнийн саналд НӨАТ, холбогдох татвар хураамж, НТТТ-ийн хангамжийн агуулах хүртэлх зардал, нэмэлт бусад зардлууд бүрэн шинэгсэн байна.</i>
ТООЗ 16.1	Тендерийн валют: <i>[Төгрөг байна.]</i>
ТООЗ 18.4	Дотоодын давуу эрхийн зөрүү: <i>“тооцохгүй”</i>
ТООЗ 20.1	Тендер нээснээс хойш 45 хоногийн туршид хүчинтэй байна.
	Г. Тендер ирүүлэх
ТООЗ 23.3 (б)	Тендер хүлээн авах захиалагчийн хаяг: Уг тендер нь цахим тендер шалгаруулалтын журмаар зохион байгуулагдаж байгаа тул тендерт оролцогч нь Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-д өөрийн аж ахуйн нэгжийн нууцлалын кодоор нэвтрэн орж тендерийн материалаа цахим хэлбэрээр ирүүлнэ. Тендер хүлээн авах этгээд: <i>[Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга Ю.Буянхишиг]</i> Байгууллагын хаяг: <i>[Сүхбаатар дүүрэг. 6-р хороо, бага тойрог. НТТТ-ийн АВТОБААЗ. 203 тоот]</i> Улс: <i>Монгол Улс</i>
ТООЗ 24.1	Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь: Огноо: <i>[2019 оны 04 дүгээр сарын 15 ны өдөр]</i> Цаг: <i>[10 цаг 00 минут]</i>
	Д. Тендерийг нээх, үнэлэх
ТООЗ 28.1	Тендерийн нээлт хийх газрын хаяг нь дор өгөгдөв. Үүнд: Байшин, гудамжны нэр: <i>[Сүхбаатар дүүрэг. 6-р хороо, бага тойрог. НТТТ-ийн АВТОБААЗ. 106 тоот]</i> Тендерийн нээлт хийх огноо, цаг нь: Огноо: <i>[2019 оны 04 дугаар сарын 15 ны өдөр]</i> Цаг: <i>[11 цаг 00 минут]</i>
	Е. Гэрээ байгуулах эрх олгох

ТӨӨЗ 40.1	Шалгарсан тендерт оролцогч гэрээний маягтыг хүлээн авснаас хойш ажлын 5-аас дээш хоногийн дараа ТШӨХ-д тусгайлан заасан хугацаанд багтаан түүнд гарын үсэг зурж захиалагчид хүргүүлнэ.
------------------	--

Гурав. **ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ**

1. **Захиалгачийн нэр:** Нийслэлийн түргэн тусламжийн төв
2. **Барааны тодорхойлолт:** Багаж, техник хэрэгсэл
3. **Стандарт:** Барааны техникийн тодорхойлолтонд заасны дагуу бэлтгэн ирүүлэх
4. **Баглаа, боодол:** Үйлдвэрийн стандарт сав баглаа боодол
5. **Чанарын баталгаат хугацаа:** 1 жилээс дээш
6. **Бараа хүргэх газар:** Сүхбаатар дүүргийн 6-р хороо Нийслэлийн түргэн тусламжийн төвийн автобааз аж ахуйн хангамжийн албанд
7. **Бараа нийлүүлэлтийн хуваарь**

Багц №1 Контторын техник хэрэгсэл

№	Барааны нэр	Хэм нэгж	Тоо ширхэг	Техникийн тодорхойлолт, чанар, үзүүлэлт, стандарт
1	Зөөврийн компьютер i7 /иж бүрэн/	ш	1	<ul style="list-style-type: none"> - Загвар i7 - FHD 15-17 инч хэмжээтэй - Windows 10 - 1920-1080-с дээш нягтралтай - 8GB- с дээш DDR4 2400MHzRAM - 500GB-2 TB SATA HHD+SSD - HDMI, 2USB3.1, USB 2.0, LAN, WI-FI, Bluetooth - Камер HD 720 P Digital microphone - Nvidia эсвэл AMD - 2 tuned speakers - Батерей 7 цагаас дээш ажиллах - Хулганатай - Цүнхтэй
2	Принтер	ш	1	<ul style="list-style-type: none"> - A4 цаасны хэмжээтэй - Хар принтер - хэвлэх, хувилах, сканнер
3	Принтер	ш	1	<ul style="list-style-type: none"> - A3, A4 цаасны хэмжээтэй

				<ul style="list-style-type: none"> - Фото, Өнгөт принтер - 3-4 үйлдэлтэй /хэвлэх, хувилах, скайнер, факс/ - Хэвлэх хурд: минутанд Хар15, Өнгөт 10 - Нягтрал: 4800*2400 - Санах ой: 256мв -с дээш - USB LAN Wireless Bluetooth холболттой
4	Проектор	ш	1	<ul style="list-style-type: none"> - Нягтаршил 1024*768 - Гэрлийн тодрол 3000 - Ламп 5000-с дээш цаг ажиллах
5	Хяналтын камерын систем	ш	2	<ul style="list-style-type: none"> - NVR – 16 сувагтай - HDMI болон VGA гаралттай
6	ТВ Hard 2	ш	2	<ul style="list-style-type: none"> - Багтаамж 4tb-с дээш

Багц №2 Эмнэлгийн болон автомашины багаж төхөөрөмж

1	Зүрхний бичлэгийн аппарат	ш	10	<ul style="list-style-type: none"> - 3 каналттай - Өгөгдөл дамжуулалт: 18bit/1000Hz - Бичлэгийн горим: Manual mode; Auto 1; Auto 2; Auto 3 - Филтер: AC, EMG drift Filter - Оролтын утга: $\leq 0.1\mu A$ - Оролтын эсэргүүцэл : $\geq 2.5M\Omega$ - Тохируулгын хүчдэл : $1mV\pm 2\%$ - Тогтворжих хугацаа $> 3.2s$ - Давтамжийн утга : 0.05 ~150Hz - Бичих хурд: 25,50mm/s($\pm 3\%$) - Хэвлэх горим: Дулааны аргаар - Цаасны хэмжээс: 50mmx20mm - LCD дэлгэц: 20x2 character LCD display status. - Стандарт: IEC60601-1 class I, type CF - Тэжээл хангамж: AC: 110V/220V/85~265V,50/60Hz$\pm 1Hz$; 30VA DC : 12V(1500mAh)
2	Автомашины компьютер оношлогооны	ш	1	<ul style="list-style-type: none"> - Загвар: Launch X431V төхөөрөмж - Үйлдэлийн систем: Android 7.0 - CPU: Quad-core 1.3GHz processor

	<i>аппарат</i>			<ul style="list-style-type: none"> - <i>Ажиллах цаг:</i> 7000mAh - <i>Memory:</i> 1GB - <i>Багтаамж:</i> 16GB - <i>LCD дэлгэц:</i> 0.1 инч - <i>LCD дэлгэцний хэмжээ:</i> 1280*800 - <i>Камерь:</i> 5.0 mega pixels and 2.0 mega pixels front - <i>Wi-Fi:</i> Support 802.11a/b/g/h, Bluetooth <i>Ажиллах температур:</i> 0°C - 45°C - <i>Хадгалах температур:</i> -20°C - 70°C
3	<i>Гар станц</i>	<i>ш</i>	8	<ul style="list-style-type: none"> - <i>Гаралтын чадал:</i> 4/5Ватт - <i>Суваг:</i> 16 - <i>MIL STD 810 CDE болон IP-54, ALT шалгууруудыг хангасан</i> - <i>Давтамжийн зурвас:</i> 150-174, 403-425, 450-474 мгц - <i>Цэнэг бүрэн авалтын хугацаа 3-4 цаг</i> - <i>Цэнэгээ барих хугацаа 8-11 цаг (10% нэвтрүүлж 90% хүлээх горимд NI MH батерей)</i> - <i>Стандарт түргэн цэнэглэгчтэй</i> - <i>Станцийн иж бүрдэлд станц, батерей, антенн, бүсний хавчаар, Түргэн цэнэглэгч заавар холбогдох материалууд</i> - <i>Жин 420гр-с ихгүй</i>

1. Барааны жагсаалт ба бараа нийлүүлэлтийн хуваарь

[Захиалагч энэхүү хүснэгтийн 1-7 хүртэлх баганыг, тендерт оролцогч 8 дугаар баганыг тус тус бөглөнө].

Нэр	Барааны тодорхойлолт	Хэмжих нэгж	Тоо ширхэг	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг (Ажлын талбай)	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Бараа нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Бараа нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа (Тендерт оролцогч энэ баганыг бөглөнө)
1	2	3	4	5	6	7	8
[Дугаар бичих]	[Барааны товч тодорхойлолтыг бичих]	[Хэмжих нэгж бичих]	[нэгжийн тоо ширхэгийг бичих]	[Бараа хүргэх газрын нэр]	[Гэрээ хүчин төгөлдөр болсноос хойших хугацааг бичих]	[Гэрээ хүчин төгөлдөр болсноос хойших хугацааг бичих]	[Гэрээ хүчин төгөлдөр болсноос хойших хугацааг бичих]
Багц1. Конторын техник хэрэгсэл							
1	Зөөврийн компьютер i7 /иж бүрэн/	ш	1	Сүхбаатар дүүргийн 6-р хороо, Түргэн тусламжийн төвийн ааò î áààç, аж ахуйн агуулах	5 сарын 10	5 сарын 14	
2	Принтер	ш	1		5 сарын 10	5 сарын 14	
3	Принтер	ш	1		5 сарын 10	5 сарын 14	
4	Проектор	ш	1		5 сарын 10	5 сарын 14	
5	Хяналтын камерын систем	ш	2	Сүхбаатар дүүргийн 6-р хороо, Түргэн тусламжийн төвийн	5 сарын 10	5 сарын 14	
6	ТВ Hard 2	ш	2		5 сарын 10	5 сарын 14	

7	Ариутгалын рулон уут	ш	20	ààò î áààç, аж ахуйн агуулах	5 сарын 10	5 сарын 14	
---	----------------------	---	----	------------------------------	------------	------------	--

Багц2. Эмнэлгийн болон автомашины багаж төхөөрөмж

1	Зүрхний бичлэгийн аппарат	ш	10	Сүхбаатар дүүргийн 6-р хороо, Түргэн тусламжийн төвийн ààò î áààç, аж ахуйн агуулах	5 сарын 10	5 сарын 14	
2	Автомашины компьютер оношлогооны аппарат	ш	1		5 сарын 10	5 сарын 14	
3	Гар станц	ш	8		5 сарын 10	5 сарын 14	

Дөрөв. **ЖИШИГ МАЯГТ**

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширх эг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БҮЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | | |
|--|-------|--|
| 1. Шалгах болон турших | 1.1. | Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана. |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. | Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх | 3.1. | Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна. |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх | 4.1. | Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно. |
| 5. Баталгаат засварын хугацаа | 5.1. | Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа [моо] жил байна. |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах | 6.1. | Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй. |
| 7. Төлбөр | 7.1. | Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш [ГТН-д заасан моо] хоногийн дотор шуурхай хийнэ. |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь | 8.1. | Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө. |
| 9. Алданги оногдуулах | 9.1. | Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. |
| 10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах | 10.1. | Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна. |
| 11. Маргааныг шийдвэрлэх | 11.1. | Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана. |

Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- | | |
|---|--|
| 1. Шалгах болон турших (ГЕН – 1) | 1.1. [Гэрээний ерөнхий нөхцөлийн 1 дүгээр зүйлийг дэлгэрүүлэх шаардлагатай бол ямар шалгалт болон туршилтыг хэн, хэзээ хийх нөхцөлийг заана.] |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2) | 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:
<ul style="list-style-type: none">1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;5) барааны гарал үүслийн гэрчилгээ. <p>Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.</p> |
| 3. Баталгаат засвар (ГЕН-5) | 5.1. Баталгаат засварын тусгай шаардлага.
<p>[Гэрээний ерөнхий нөхцөлийн 5 дугаар зүйл нь баталгаат засварын тухай нийтлэг заалтыг агуулна. Энэхүү нийтлэг заалтыг өөрчлөх шаардлага гарвал энд тусгана.]</p> |
| 4. Төлбөр (ГЕН – 7) | 7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:
<p>Гэрээний үнийн дүнгийн [moo]¹хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө.</p> |
| 5. Алданги оногдуулах (ГЕН - 9)² | 9.1. Алданги оногдуулах хувь: [moo]
<p>Алдангийн нийт дүн: [moo]</p> |

¹Ихэнх тохиолдолд 100 хувь байна. Шаардлагатай бол төлбөрийн хуваарийг өөрчилнө.

² Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.

Долоо. ГЭРЭЭНИЙ МАЯГТ³

БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧ

НИЙЛҮҮЛЭГЧ

(Тамга, тэмдэг)

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны ____ сарын ____ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг _____ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь _____ нэр төрлийн барааг _____ оны __ дугаар сарын ____ -наас _____ оны __ дугаар сарын ____ -ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Бусад шаардлагатай баримт бичиг⁴;
Үнийн санал;
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
Санхүүжилтийн хуваарь.

³ Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

⁴ Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
*[Гарын үсэг]*_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
*[Гарын үсэг]*_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]